

ӨГҮҮЛЭЛ

**Улс орнуудын цар тахалтай тэмцэж буй арга барил,
засаглалын чадамж****Намсрайдоржийн Гэрэлт-Од**

Магистр, судлаач, Аюулгүй байдал судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
gerelt-od@niss.gov.mn

Хураангуй: Дэлхийн түүхийн сүүлийн 100 жилд тохиож байгаагүй хамгийн их хохирол дагуулж байгаа цар тахлын хүнд үеийг улс орон бүр өөр өөрийнхөөрөө удирдан зохицуулж байна. Цар тахал улс орнуудын манлайлал, засаглалын ялгаатай байдал, түүний давуу болон сул талыг илрүүлж байна. Тэгвэл гамигийн энэ цаг үед ямар менежмент хэрэгжүүлсэн нь амжилт олж, ямар нь амжилт олохгүй байна вэ? Энэ нь тухайн улсын улс төрийн дэглэмтэй (засаглалын хэлбэр) харилцан хамааралтай эсэхийг ардчилсан, авторитар болон тоталитар дэглэмтэй түүнчлэн бусдаас онцлог арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа улс орнуудын цар тахлын менежментийн кэйсийг харьцуулан судлалаа.

Түлхүүр үг: Цар тахал, улс төрийн дэглэм, засаглал, менежмент

Оршил

Энэхүү өгүүлэлд ардчилсан дэглэмтэй Америкийн Нэгдсэн Улс, Шинэ Зеланд, авторитар дэглэмтэй Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Исламын Бүгд Найрамдах Иран Улс, тоталитар дэглэмтэй Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Бүгд

Найрамдах Куба Улс, цар тахлын онцлог менежмент хэрэгжүүлж буй Швед улс болон Европын Холбооны улсын нэг Австри улсын ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, стратегийг харьцуулан судлалаа. Улс төрийн дэглэм тус бүрт

Received: 23 June, 2021; Accepted: 30 June, 2021

<https://orcid.org/0000-0002-1023-2476><https://creativecommons.org/licenses/by/4.0/>

сонгон авсан улсууд нь цар тахлын менежментийг харьцангуй амжилттай зохион байгуулж буй болон нилээд бэрхшээлтэй тулгарч буй улсын аль аль нь байна. Тиймээс аливаа байгалийн гамшиг болон давагдашгүй хүчин зүйлийн менежмент, улс төрийн дэглэмийн хооронд харилцан уялдаа харагдахгүй байгаа буюу энэ үед аль нэг дэглэм нь нөгөөгөөсөө илүү бус байна.

Судалгааны арга зүй: Уг судалгаа нь харьцуулсан улс төр судлалын парадигмын хүрээнд хийсэн кэйс судалгаа болно. Тодруулбал судалгааны объект болгон түүвэрлэж авсан улс

орнуудыг улс төрийн дэглэмээр нь ангилан, цар тахлын үед авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, стратегийг шийдвэр гаргах түвшин, эрүүл мэндийн салбар, мэдээллийн салбар, иргэдийн хариуцлага гэсэн дөрвөн чиглэлээр задлан харьцуулж судлалаа. Цар тахлын менежментийг засаглалын хэлбэрээр авч үзэхээс гадна удирдлагын арга барил талаас нь судалсан судалгаанууд мөн байдгийг дурдууштай. Хэрвээ удирдлагын загвараар нь судлах бол шинжээчдэд Л.Мьюлманы арга зүйг хэрэглэх боломжтой гэдгийг санал болгож байна.

Ардчилсан дэглэм ба цар тахлын менежмент

Ардчилсан дэглэмтэй орнуудын төлөөлөл болгон дэлхийн ардчиллын манлайлагч АНУ, хөгжиж буй жижиг улс Шинэ Зеландыг авч үзлээ.

АНУ: Холбооны улс тул муж улс бүр өөр өөрийн хуулийн дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлж, хөл хориог харилцан адилгүй хугацаанд тогтоох, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс болгоомжлон заавал дагаж мөрдөх хатуу хорио цээр тогтоохгүй байх зэрэг нэгдмэл бус менежментийг хэрэгжүүлжээ. Цагаан Ордны зүгээс муж улсуудыг нэгтгэн гамшгийн үеийн нэгдсэн хариу арга хэмжээ авах алхам хийгээгүй, менежментийг муу хийсэн гэж судлаачид үзэж байна.

Шийдвэр гаргах түвшинд: Аюулыг үл тоомсорлож мэргэжилтнүүдийн

үгийг ойшоогоогүй. Тухайн үеийн ерөнхийлөгч Д.Трамп болон зарим нөлөө бүхий улс төрчид цар тахлыг түр зуурын энгийн ханиад мэтээр үзэн үл ойшоож байв. Цар тахлын эхэн үед Д.Трампын засаг захиргааны зүгээс Америкийн Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвийн мэдэгдэлийг хянаж байжээ.¹ Ийнхүү цар тахлын эхэн үед америкчууд бодит байдлыг доогуур үнэлснээс халдварыг хяналтаасаа алдсан ба нэгэнт алдсан тохиолдолд хүн ам ихтэй энэ улсад тархалтыг хумих нь маш хэцүү болжээ. Гамшгийн үед хариу арга хэмжээ авах үндэсний хэмжээний нэгдсэн стратегигүй, муж улс бүр өөр өөрийн хууль журмын дагуу зохион байгуулж байгаа нь харилцан адилгүй үр дүнг үзүүлж тархалтыг хянахад сөргөөр нөлөөлж байгаа аж.

1 How the U.S. Pandemic Response Went Wrong- and What Went Right-during a Year of COVID <https://www.scientificamerican.com/article/how-the-u-s-pandemic-response-went-wrong-and-what-went-right-during-a-year-of-covid/>

Эрүүл мэндийн салбарт: Ийнхүү халдвар хурдацтай тархаж байхад оношлох, шинжилгээ авах ажлын бэлтгэл сул, удаан байсан гэж ажиглагчид үзэж байна. Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төв нь бүрэн хангалттай ажиллаж чадаагүй ба өөрсдийн боловсруулсан тестээр шинжилгээ авах үед оношлуур алдаатай зааж байсан нь халдварыг хурдацтай тарахад нөлөөлжээ. Ийм асуудал байсаар атал Хүнс эмийн хяналтын агентлаг хувийн компаниудад шинжилгээ хийх эрх олгоход удаан хойрго хандсаны зэрэгцээ өвчний эхний үед шинжилгээ авахад хатуу заалттай байсан буюу хэд хэдэн шинж тэмдэг илэрсэн, сүүлийн өдрүүдэд эрсдэлтэй бүс нутгаар зорчсон тохиолдолд эмнэлэгт хандан шинжилгээнд хамрагдаж байсан нь халдварыг хурдасгахад нөлөөлсөн гэж Жонс Хопкинсийн их сургуулийн эрүүл мэндийн аюулгүй байдлын эпидемиологичид үзэж байна. Салбарын эрдэмтэд шинжээчид санал дүгнэлтээ нэгтгэхдээ удаан, Хүнс ба эмийн агентлаг түүнийг батлаж мөрдүүлэхдээ ч мөн хөшүүн байна гэж судлаачид шүүмжилжээ.

Мэдээллийн ил тод байдал: Мэдээллийн эрх чөлөөг хангахад чухал ач холбогдол өгдөг АНУ цар тахлын эхэн үед мэргэжлийн байгууллагын мэдэгдэлд цензур тавьж байсан байна. Түүнчлэн цар тахлын эхэн үед мэргэжлийн том байгууллагууд болох ДЭМБ, Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвийн байр суурь зөрүүтэй байж, улс төрчид нөхцөл байдлыг улс төржүүлсэн нь олон нийтийг төөрөгдүүлж урьдчилан сэргийлэх арга

хэмжээний эрчийг сулруулжээ.

Иргэдийн хариуцлага: Хавьтлыг тогтоох, тусгаарлах арга хэмжээ нь гоц халдварт өвчний үед чухал шаардлагатай ажил атал үүнийг хувийн эрх чөлөөгөөрөө бахархдаг, хувь хүний эрхийг нэгдүгээрт тавьдаг америкт хэрэгжүүлж чадаагүй нь энэ байдалд хүрэхэд түлхэц өгчээ.

Шинэ Зеланд: Цар тахлыг хамгийн амжилттай зохицуулж байгаа улсын нэгээр дэлхий нийт Шинэ Зеландыг нэрлэж байна. Тус улс 2002 онд боловсруулж 2017 онд шинэчилсэн Үндэсний цар тахлын стратеги төлөвлөгөөнийхөө дагуу хариу арга хэмжээг авч ажиллажээ. Уг төлөвлөгөөний дагуу холбогдох яамдын шийдвэр гаргах түвшний удирдлагын баг байдаг ба энэ баг тахлын үед өөрсдийн гүйцэтгэх чиг үүргийн дагуу ажлаа уялдуулан шуурхай ажилладаг байна. Уг багийг Эрүүл мэндийн яам тэргүүлэхээр томилогдсон бөгөөд Онцгой байдлын газар техникийн дэмжлэг үзүүлэх гэх мэтчилэн бусад яамд агентлагууд туслах, дэмжих чиг үүргээр ажиллаж байна.

Шийдвэр гаргах түвшинд: Шинэ Зеландын парламентаас хоёр шинэ институцийг зохион байгуулсан байна. Нэг нь ерөнхий сайд болон долоон сайдаас бүрдсэн тахлын эхэн үед засгийн газрын ковид-19-ийн үйл ажиллагааны шийдвэрийг үр дүнтэй зохион байгуулах гүйцэтгэх чиг үүрэгтэй Сайд нарын бүлэг, нөгөө нь хяналт тавих чиг үүрэгтэй Цар тахлын хариу арга хэмжээний хороо юм. Хороо нь сөрөг хүчин болох Үндэсний намаар удирдуулсан парламентийн янз бүрийн

бүлгийн төлөөлөл бүхий 11 гишүүнээс бүрджээ. Цар тахлын эрсдлийг үнэлэх дөрвөн түвшинг тогтоосон бөгөөд халдварын тархалтаас шалтгаалан аль салбар ямар хугацаагаар ажиллах, хаах, ямар үйл ажиллагааг хориглох, халдварын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс шалтгаалан аль түвшинд шилжих зэрэг тодорхой ойлгомжтой мэдээллийг ард иргэддээ хүргэсэн байна. Цар тахлын эсрэг үндэсний стратегийг хэрэгжүүлэх “удирдлагын бүх түвшин”(all-of-government approach) хэмээх арга нь шуурхай арга хэмжээ авч уян хатан зохицуулалт хийх системийг бий болгожээ. Уг арга нь холбогдох салбаруудад тодорхой арга хэмжээ, үйл ажиллагааг өргөн хүрээнд авч хэрэгжүүлэх, жижиг гүйцэтгэх багуудад уян хатан шийдвэр гаргах боломж олгодог арга юм. Засгийн газар, улс төрчид, удирдлагуудын ойлголт нэгдмэл, ард иргэдэд өгөх мессеж тодорхой, ойлгомжтой, төөрөлдүүлхээргүй байв.

Эрүүл мэндийн салбарт: Өмнө нь 2003, 2009, 2019 онуудад дэгдсэн хүнд хэлбэрийн томуу болон улаан бурханы дэгдэлтийн үеэр хуримтлуулсан туршлага болон ковидын халдвар дэгдэж байгаа бусад орны туршлагад тулгуурлан шинжлэх ухааны нотолгоонд суурилсан хариу арга хэмжээг шуурхай авч хөл хориог үр дүнтэй тогтоосон. Цар тахал намжиж, тохиолдол бүртгэгдэхээ больсон үед ч оношлох, тархвар илрүүлэх хүчин чадлаа сайжруулж хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлсээр байсан нь хоёр дахь давалгааг газар авахуулалгүй хумихад нөлөөлжээ.²

Мэдээллийн ил тод байдал: Хариу арга хэмжээний хороо нь тахлын эхэн үед холбогдох албан тушаалтнуудтай цахим сонсголыг тогтмол явуулж байсан ба энэ сонсголыг иргэдэд нээлттэй шууд дамжуулж байсан нь үр дүнтэй байжээ. Хорооны үйл ажиллагаа парламентын хуралдааны чөлөөт цагаар явагдсан бөгөөд парламентын хуралдаан эхлэхэд зогссон байна. Цар тахлын менежментийг хэрэгжүүлж байгаа Эрүүл мэндийн яам туршлагатай шилдэг вируслогч, эпидемиологч, эрдэмтдийн баг байгуулсан бөгөөд уг баг засгийн газрын цензургүй, ил тод, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж байсан нь засгийн газрыг бодлого тодорхойлох, олон нийтийг бодит, сайн мэдээлэл авах боломжоор хангажээ. Ерөнхий сайд нь орой бүр фэйсбүүк олон нийтийн сүлжээгээр нөхцөл байдал, гаргах шийдвэр зэргийн талаар иргэдтэй бүтэн цагийн турш шууд харилцаж бодит мэдээллийг өгч байжээ. Эрүүл мэндийн сайд нь ч мөн адил тулгарч байгаа бэрхшээл, хэрэгжүүлж байгаа ажлынхаа талаар нээлттэй ил тод мэдээллийг тогтмол хүргэж байсан нь иргэдэд ойлгомжтой байж, бухимдал, үл ойлголцол үүсэхээс сэргийлж, нийгмийн эрүүл мэндийн асуудлаарх улс төржилтийг багасгаж чаджээ.

Иргэдийн хариуцлага: Шийдвэр гаргах түвшинд ойлголтоо нэгтгэж, мэдээллийг ил тод нээлттэй өгч, авах арга хэмжээ тодорхой байсан нь иргэдийг үүргээ ухамсарлан хариуцлагатай байхад чухал нөлөө үзүүлжээ. Энэ нь мөн иргэдийн засгийн газарт итгэх итгэлийг бэхжүүлсэн байна.

2 Policy & Institutional Response to COVID-19: New Zealand

<https://www.brookings.edu/wp-content/uploads/2021/01/MENA-COVID-19-Survey-New-Zealand-.pdf>

Авторитар дэглэм ба цар тахлын менежмент

Авторитар дэглэмтэй улсын төлөөлөл болгон цар тахал анх дэгдсэн ч амжилттай хяналтад авч чадсан БНХАУ, тахал дэгдсэн хоёр дахь улс болсон, нилээд хохирол амсаж буй Иран улсыг авч үзье.

БНХАУ: Цар тахал анх үүсч дэгдэж, нилээд хэмжээний хохирол амссан ч өдгөө байдлыг хяналтдаа авч, цар тахлын менежментийг сайн хэрэгжүүлж бусад улсад жишээ болж байна. Анх цар тахлыг таних гэж хугацаа алдсан мөн тэр үеэр үндэсний баяр Цагаан сар тохиосон нь нөхцөл байдлыг хүндрүүлсэн юм. Харин нөхцөл байдлыг хурдан хяналтдаа авч чадсан шалтгаан нь өмнө нь SARS-г даван туулсан туршлага, халдварт өвчний эсрэг хариу арга хэмжээний нэгдсэн систем, хатуу хяналт, арга хэмжээ, шуурхай оношлогоо, эдийн засгийн хүчин чадал, технологийн дэвшил байв.

Шийдвэр гаргах түвшинд: Ерөнхий сайдаар ахлуулсан Цар тахалтай тэмцэх удирдлагын баг байгуулжээ. Халдварын тархалтыг таслан зогсоох, өвчний хүндрэлийг тооцох зорилгоор цар тахлын болон түүнтэй холбоотой авч хэрэгжүүлж байгаа стратегийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, олон нийтийн дэмжлэг, төр засгийн чадавх зэрэгтээ үндэслэн дэс дараатай гурван том стратеги төлөвлөгөөг гаргасан ба одоогоор эхний хоёр нь хэрэгжиж байна. Эдгээр нь:

1. Хөл хорих – Халдвар илэрсэн бүсэд хатуу хөл хорио тогтоож,

хавьтлыг яаралтай мөшгин илрүүлж, тусгаарлах. Халдвар илэрсэн хот, тосгон бүрт 30-76 хоногийн хатуу хөл хориог тогтоож, энэ хугацаанд хавьтал бүрийг мөшгин илрүүлж, шинжилгээ авч яаралтай хариуг мэдээлэн, тусгаарлан эмчлэх ажлыг хийж байв.

2. Халдварыг хумих – Энэ стратеги нь энд тэнд янз бүрийн хэмжээний дэгдэлт үүсч тархсан газар зүйн хувьд өөр өөр, шууд хатуу хөл хорих шаардлага бага тохиолдолд хэрэгжүүлнэ. Арга хэмжээний хувьд таслан зогсоох стратегитай төстэй боловч арай сул. Эдгээр стратеги тус бүр нь нарийвчилсан үйл ажиллагааны заавар схемтэй бөгөөд хамгийн чухал болоод яаралтай үйл ажиллагаа нь сэжигтэй тохиолдол тус бүрийг шинжилгээнд хамруулж, хавьтал бүрийг илрүүлэх юм. Одоогоор тус улсын ихэнх нутагт эрсдэл бага байгаа тул энэ стратегид шилжин оржээ. Тиймээс өндөр настан, хүүхэд, жирэмсэн эх, эмнэлэгийн ажилтнууд зэрэг эмзэг бүлгийнхэн болон асрамжийн газар, хорих газар, эмнэлэг гэх мэт эрсдэлтэй газруудад гол анхаарлаа төвлөрүүлж байгаа ажээ.
3. Дархлаа тогтоох – Энэ стратеги руу харахан шилжээгүй байгаа ба халдварыг сайтар

хумьж, тархалтыг хяналтдаа авч, эмзэг бүлгийн хүн амаа хамгаалж, эрүүл мэндийн системээ хүндрүүлэхгүй хэмжээнд хүрснийхээ дараа энэ стратеги руу аажим шилжихээр төлөвлөжээ. Уг стратегийн гол арга хэмжээ нь тохиолдол, ойрын хавьтал бүрийг мөшгихөөс илүү хүнд өвчтнийг эмчлэхэд анхаарах ба ингэснээрээ сүргийн дархлаа тогтоох юм байна.

Түүнчлэн тархалтыг хумихад засаг захиргааны анхан шатны нэгж болох хороодын бүтцэд тулгуурлан зохион байгуулсан нь цар тахалтай тэмцэх ажил амжилттай болох гол шалтгаан байсан талаар “Ковид-19-тэй тэмцэх цагаан ном”-д дурджээ.

Эрүүл мэндийн салбарт: 2003 оны SARS-ийн халдварын дараа “шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа”-г яаралтай тодорхойлох эпидемиологийн тандалтын системийг бий болгон бэхжүүлжээ. Систем нь халдварын эх үүсвэр, дамжих замыг тодорхойлсноор улсын хэмжээнд дэгдэлтийг зогсоох стратегийг боловсруулахад дөхөм болжээ.³

Хүнд өвчтнүүдийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж, хөнгөн болон дунд зэрэг өвчтнүүдийг эмчлэх, тусгаарлах түр эмнэлэгүүдийг байгуулж, шинж тэмдэггүй болон сөрөг хариутай

хавьталуудыг гэрт нь тусгаарлах арга хэмжээ авсан нь үр дүнтэй байжээ. Гэсэн хэдий ч хөл хөдөлгөөн ихтэй Бээжин, Шанхай, Далянь, Хонгконг зэрэг томоохон хот, бүс нутгуудад зөөвөрлөгдөн ирсэн тохиолдлуудаас үүдэлтэй дэгдэлтийг зохицуулахад бэрхшээл учирч байгаа ажээ.

Хятад улсын “Ковид-19-тэй тэмцэх цагаан ном”-д дурдсанаар цар тахалтай амжилттай тэмцэж буй гол шалтгаан нь “эрт илрүүлэлт-эрт оношлогоо-эрт эмчилгээ” хэмээх тактик юм. Өдгөө Хятад улс вакцинжуулалтын үр нөлөөг дээшлүүлэхэд ч анхаарч байна.⁴

Мэдээллийн ил тод байдал: Цар тахал анх дэгдэхэд олон улсын түвшинд вирусны генийн дарааллыг цаг алдалгүй мэдээлснээр оношлогоо, эмчилгээ, вакцин хөгжүүлэлтэд тус болжээ. Дотооддоо мэдээллийг тодорхой түвшинд нээлттэй өгч байсан, төрөөс гаргасан түр журам, дагаж мөрдөх заавар, цар тахлын цаг үеийн талаарх мэдээллийг иргэдэд шуурхай, сайн өгч байсан байна.

Иргэдийн хариуцлага: Хятадуудын хувьд иргэний эрх чөлөөний тухай ойлголт өрнийн орнуудынхаас ялгаатай байдаг нь мөн нөлөөлсөн гэж судлаачид үзэж байна.⁵ Иргэдийн төр засагт итгэх итгэл өндөр учир төрөөс гаргасан шийдвэрийг дагаж мөрдөхдөө сайн байдаг. Олон улсын зүгээс хүний эрхийн зөрчил гаргасан гэж үздэг ч нотлоход хэцүү байна.

3 Strategies and Advances in Combating COVID-19 in China <https://www.sciencedirect.com/science/article/pii/S209580992030285X>

4 Active case finding with case management: the key to tackling the COVID-19 pandemic [https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(20\)31278-2/fulltext](https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(20)31278-2/fulltext)

5 China's successful control of COVID-19 [https://www.thelancet.com/journals/laninf/article/PIIS1473-3099\(20\)30800-8/fulltext](https://www.thelancet.com/journals/laninf/article/PIIS1473-3099(20)30800-8/fulltext)

Исламын Бүгд Найрамдах Иран

Улс: Иран улсад 2020 оны хоёрдугаар сарын 19-нд ковид-19-ийн халдвар бүртгэгдсэнээр энэ халдвар дэгдсэн дэлхийн хоёр дахь улс болсон юм. Цар тахлын нөхцөл байдал төдийлөн сайжрахгүй, хяналтад авч чадахгүй байгаагийн шалтгааныг зарим судлаачид дотоодын эсэргүүцэгчдээс болгоомжилсон удирдагчид хөл хориог оройтож тогтоож, эрт сулруулсан, хэдийгээр цэргийнхэн болон сайн дурынхан цар тахлын эсрэг ажиллаж байгаа ч үр дүнтэй хариу арга хэмжээ авч чадаагүй, хяналттайгаар бодит бус мэдээллийг өгч байгаатай холбон тайлбарлаж байна.

Шийдвэр гаргах түвшинд: Цар тахал дэгдсэн эхний үед парламентын сонгууль, Наурызын баяр гэх хоёр том арга хэмжээ болох үед ямар ч хязгаарлалт тогтоогүйн улмаас нэгэнт хяналтаас алджээ. Засгийн газраас эрүүл мэндийн даатгал, татвар, төлбөрүүдийг 3 сараар хойшлуулах, бага хүүтэй зээл олгох, нэн ядуу иргэдэд бэлэн мөнгө тараах зэргээр тодорхой хэмжээний дэмжлэгийг иргэдэд үзүүлж байгаа боловч нөхцөл байдал хүнд байгаагийн бурууг АНУ-ын хориг арга хэмжээтэй холбон тайлбарлаж байгаа нь тийм ч үндэслэлтэй бус байна. Харин тус улс түүхэндээ хамгийн том хувьчлалыг эхлүүлж байгаа буюу 18 компанийн төрийн мэдлийн хувьцааг борлуулж орлого олохоор болсон ба мөн эрүүл мэндийн салбар болон ажилгүйдлийн

даатгалын санд нэмэлт санхүүжилт олгохоо зарласан байна. Ираны хувийн хэвшлийн 200 гаруй компани нэгдэн хамгийн том хандивийн аян өрнүүлж нийгмийн чухал салбаруудад туслаж байна.⁶

Эрүүл мэндийн салбарт: Иран улс анагаахын шинжлэх ухааны сургалт болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий интеграцичлагдсан 65 сургууль/их сургуультай, бүх иргэдийнхээ эрүүл мэндийн байдлыг бүртгэж байдаг бүртгэлийн систем бүхий өвөрмөц эрүүл мэндийн тогтолцоотой улс бөгөөд хувийн хэвшлийн болон улсын эмнэлэгийн нийт 130 000 ортой ч халдварын огцом өсөлтөөс үүдэн орны хомсдолд оржээ. Түүнчлэн эпидемиологчдыг яаралтай томилж ажиллуулаагүй хугацаа алдсан, улсын хэмжээнд 50 лабораторид мэдрэг чанар өндөртэй, өвөрмөц оношлогооны иж бүрдлийг боловсруулж, хөгжүүлж байгаа боловч халдварын тохиолдлуудад хэрэглэх боломжгүй байсаар байна. Ковид-19-ийн хөнгөн хэлбэрээр өвдсөн болон эмчлэгдээд эдгэсэн өвчтнүүдийг байрлуулах сувилалын төвүүдийг байгуулсан хэдий ч тэдгээрийн үйл ажиллагааг цэргийнхэн зохион байгуулж эмч, сайн дурын ажилтнууд ажиллаж байна.⁷

Мэдээллийн ил тод байдал: Иранд цар тахалтай холбоотой аливаа мэдээллийг хянаж байгаа ба үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн хэмээн шийтгэл оногдуулахаар болсон тул

6 Iran and COVID-19: Timing Matters

<https://mideast.prio.org/utility/DownloadFile.aspx?id=38&type=publicationfile>

7 COVID-19 Management in Iran as One of the Most Affected Countries in the World: Advantages and Weaknesses <https://www.frontiersin.org/articles/10.3389/fpubh.2020.00510/full>

албан ёсны статистик нь ч эргэлзээ төрүүлэхээр байна.

Иргэдийн хариуцлага: Засгийн газрын зүгээс нэгдсэн, ойлгомжтой мэдээллийг ил тод өгөхгүй байгаагаас иргэдийн дунд төөрөгдөл үүсч, бодит бус, ам дамжсан мэдээлэлд итгэснээс урьдчилан сэргийлэх болон эмчилгээний аргыг буруу сонгон амь насаа алдах хүртэл эрсдэл үүсч байлаа. Мөн засгийн газартаа итгэх итгэл сулаас үүдэн иргэдийн эсэргүүцэл гарч энэ нь эргээд цар тахлыг хумихад

сөргөөр нөлөөлжээ.

Хариу арга хэмжээг хугацаа алдаж авсан, бодит бус мэдээллийг түгээж байгаа, эпидемиологчдын оролцоо хязгаарлагдмал, нэгдсэн нэг төлөвлөгөөгүй нь иргэдийг төөрөгдүүлж хэрэгжилтийг удаашруулж байгаа зэрэг байдал нь тус улсыг цар тахлын нөхцөл байдлыг хяналтаасаа алдаж өнөөгийн нөхцөлд хүрэхэд нөлөөлж байна гэж судлаачид үзжээ.

Тоталитар дэглэм ба цар тахлын менежмент

Улс төрийн дэглэмийн хувьд тоталитар дэглэмтэй бүрэн хаалттай улс болох БНАСАУ, бүрэн хаалттай бус ч хяналт өндөртэй Куба улсыг авч үзвэл:

БНАСАУ: Хойд Солонгосыг ажиглагчид тус улсын коммунист систем нуран унаж, цөмийн хөтөлбөр эцэс болоход олон улсын хоригоос цар тахал илүү хүчтэйгээр нөлөөлж болзошгүй гэж таамаглаж байлаа.

Шийдвэр гаргах түвшинд: 2020 оны нэгдүгээр сарын 23-нд буюу ДЭМБ коронавирусын дэгдэлтийг цар тахал хэмээн зарлахаас долоо хоногийн өмнө тус улс хилээ хаажээ. Өнөөдрийг хүртэл Хойд Солонгост ковид-19-ийн нэг ч тохиолдол бүртгэгдээгүй байна. Албан ёсны статистикийг үл харгалзан сансрын зургаас харахад нийтийг хамарсан үхэл болж байгаа гэх ямар ч шинж ажиглагдахгүй байгаа ажээ.

Тус улсын цар тахлыг зохицуулах гол арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх буюу дотооддоо халдвар оруулж ирэхгүй байхад бүх анхаарлаа

хандуулж иргэдийг хяналттай, сахилга баттай байлгах арга хэмжээг авч байгаа ажээ. Дотооддоо халдвар хамгааллын дэглэм зөрчсөн нэг иргэнийг цаазаар авсан талаар Өмнөд Солонгосын тагнуулын агентлаг мэдэгджээ.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хөрш орнуудтайгаа хийх худалдааг удаашруулахын зэрэгцээ хилийн хориг, хил хамгаалалтаа урьд өмнөхөөс илүү чангатгаж хэн ч үл нэвтрэх хориотой буфер бүсийг тусгайлан байгуулжээ. Түүнчлэн дотооддоо төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ковид-19 өвчний шинж тэмдэг, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар сурталчилсан байна.

Гэхдээ байгалийн элдэв гамшигт үзэгдэл, давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр эдийн засгийн таван жилийн төлөвлөгөө тасалдахад хүрсэн гэдгийг БНАСАУ-ын Төрийн зөвлөлийн дарга Ким Жон Ён 2021 оны нэгдүгээр сард болсон Солонгосын Хөдөлмөрийн Намын VIII их хурлын үеэр хүлээн

зөвшөөрсөн юм.

Хууль тогтоох байгууллагын дэргэдэх Мэдээллийн хорооны мэдэгдсэнээр тус улс ковид-19-ийн оношлогоо хийх тоог нэмэгдүүлж зарим тохиолдолд Кэсон, Хисан, Нампо, Пёнян хотод хөл хорио тогтоосон байна. Нөгөө талаас нь харвал цар тахал энэ улсын улс төрийн дэглэмийг улам бэхжүүлж байгаа байж болзошгүй юм.⁸

Эрүүл мэндийн салбарт: БНАСАУ-ын Төрийн зөвлөлийн дарга Ким Жон Ын өнгөрсөн нэг жилийн хугацаанд харьцангуй цөөн олон нийтийн өмнө гарсан, дээр дурьдсан хотуудад хөл хорио тогтоосон зэргийг зарим ажиглагчид тус улсад халдварын тохиолдолд бүртгэгдсэн байж болзошгүй гэж таамагладаг ч нотлогдож байгаагүй юм.

Мэдээллийн ил тод байдал: Дээр дурьдсан арга хэмжээнд үндэслэн олон улсын зүгээс тус улсыг энэхүү цар тахлын үед нилээд экстрим арга хэмжээ авч байна гэж үзэж байна. Мэдээлэл хаалттай тус улсаас олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагууд үндсэндээ гарсан тул цар тахлын талаарх бодит мэдээлэл маш хомс байна.

Иргэдийн хариуцлага: Олон жилийн турш хаалттай байж ирсэн, эдийн засгийн болон бусад эрх чөлөө хязгаарлагдмал, нам, төрийн хяналт чанга улс тул нэгэнт цар тахлыг дотооддоо алдахгүй байж чадаж байгаа энэ нөхцөл байдалд ажрахгүй байгаа бололтой. Цар тахлын үед энэ улсын хилийг нэвтэрч чадах ганц зүйл нь вакцин болж байх шиг байна.

Хэдийгээр бусад төрлийн тусламжийг авахаас татгалзаж байгаа ч вакцины хувьд өөр байх бололтой.⁹

БНКУ: Куба бол нийгмийн эрүүл мэндийн систем сайтай, хүн амыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулдаг учир эмзэг бүлгийн бүртгэл, хяналт, мэдээллийн сан сайн, урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үйлчилгээнд олон жилийн турш хөрөнгө оруулалт хийж ирсэн, халдварт өвчнүүдийг устгасан туршлагатай улс юм. Мөн вакцин хөгжүүлэлтийн туршлагатай тул үүндээ тулгуурлан дөрвөн төрлийн вакциныг хөгжүүлж байна. Эдгээр туршлагадаа тулгуурлан цар тахалтай тэмцэх стратегийг харьцангуй сайн төлөвлөж хэрэгжүүлж байгаа гэж мэдэгдэж байгаа ч бүс нутгийн хэмжээнд тийм ч сайн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

Шийдвэр гаргах түвшинд: Цар тахал анх дэгдэх үед буюу 2020 оны нэгдүгээр сард Куба улс “урьдчилан сэргийлэх, хянах” төлөвлөгөөг гарган ажилласан ба энэ төлөвлөгөөнд эмнэлгийн ажилтнуудыг сургах, тусгаарлах, эмчлэх байруудыг бэлтгэх, цар тахлаас урьдчилан сэргийлэх болон түүний шинж тэмдгийн талаар олон нийтэд анхааруулах зэрэг ажлууд багтжээ. Тиймээс 2020 оны гуравдугаар сарын 11-нд эхний зөөвөрлөгдсөн гурван тохиолдол батлагдахад уг төлөвлөгөөний дагуу шуурхай ажиллан хавьталуудыг олох, тусгаарлах, эмзэг бүлгийнхэнийг анхаарах, өрх бүрийг шинжилгээнд

8 COVID-19 in North Korea <https://www.policyforum.net/covid-19-in-north-korea/>

9 No cases? No chance. The truth about North Korea and Covid-19 <https://www.wired.co.uk/article/north-korea-covid-news>

хамруулах зэрэг ажилд анагаахын чиглэлээр суралцдаг оюутнуудыг дайчлан ажиллуулжээ.¹⁰

Гэсэн хэдий ч энэ үед улс даяар хөл хорио тогтоохгүй байсаар 2020 оны гуравдугаар сарын 20-нд улс даяар хөл хорио тогтоож 24-нд хилээ хаажээ. Учир нь тус улсын эдийн засгийн нилээдгүй хувийг бүрдүүлдэг эрүүл мэндийн аялал жуулчлалаас шалтгаалан ийнхүү харзсан ажээ. Хөл хорио тогтоох үеэр буюу гуравдугаар сарын 22-нд 37 000 гаруй хүнээс шинжилгээ авахад 40 тохиолдол батлагдажээ. Гэсэн ч дээрх шалтгаанаас үүдэн дотоодын аялал жуулчлалыг зургаадугаар сарын нэгнээс, хилээ долоодугаар сарын нэгнээс тус тус нээжээ.

Нөгөө талаас АНУ-ын хориг нь эрүүл мэндийн анхан шатны бараа материал импортлох засгийн газрын санхүүгийн чадавхийг сааруулжээ. Мөн хүн амын орон байрны хүрэлцээ хангамж муугаас шалтгаалан хэт бөөгнөрөн амьдардгаас халдвар буурахгүй байх, хүнс тэжээлийн ихэнх хэсгийг гадаад орнуудаас авдагаас хүнсний аюулгүй байдал алдагдан чанаргүй хүнс хэрэглэх болсон, дэд бүтэц муу зэрэг нь бэрхшээл учруулж байна.¹¹ Кубын засгийн газраас эдийн засгийн шинэчлэл хийхээр зорьж байгаага мэдэгдсэн нь дээрх бэрхшээлүүдээ шийдэхэд тус болох юм.

Эрүүл мэндийн салбарт: Тус улс чадварлаг, бүс нутагтаа халдварт өвчний чиглэлээр ажилласан туршлагатай эрүүл мэндийн

ажилтнуудтай, нэгдсэн эрүүл мэндийн системтэй, иргэдийг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, хянаж байдаг, дотооддоо халдвар алдахаас өмнө бэлтгэл хийсэн зэрэг давуу талууд байна. Түүнчлэн ур чадвар сайн, сайтар бэлтгэгдсэн эмч, эрүүл мэндийн ажилтнуудтай, цар тахал анх дэгдэхэд буюу 2020 оны нэгдүгээр сард эрүүл мэндийн ажилтнуудаа Уханьд илгээж ажиллуулсан хэдий ч энэ нь эргээд нарийн мэргэжлийн эмчийн хомсдолыг үүсгэж өөр мэргэжлийн эмч нарыг цар тахлыг эмчлэхээр сургах шаардлага үүсч, үйлчилгээний хүртээмжийг бууруулсан гэж шүүмжлэгчид үзжээ. Мөн эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан алслагдсан нутгийн зарим эмнэлгийг хаасан нь бүсийн эмнэлгийн ачааллыг нэмэгдүүлжээ.

Мэдээллийн ил тод байдал: Хөл хорионы дэглэмээр халхавчлан хараат бус сэтгүүлч, идэвхтэнүүдийг хорих, хянах нь газар авсанаас үүдэн халдварын тархалтын болон нас баралтын талаарх мэдээллийн бодит эсэхэд шүүмжлэгчид эргэлзэж байгаа ажээ.

Иргэдийн хариуцлага: Кубын төвлөрсөн төрийн хяналттай эдийн засгийн тогтолцоо нь цар тахлын үед харилцан уялдаатай, түргэн шуурхай хариу арга хэмжээ авахад дөхөм байсан хэдий ч иргэд нь төрийн үйлчилгээнээс өндөр хамааралтай, бие даан амьдрах, эрсдэлээс хамгаалах, хариу арга хэмжээ авах чадвар султай болжээ гэж зарим ажиглагчид дүгнэжээ.¹²

10 Coronavirus response: why Cuba is such an interesting case

<https://theconversation.com/coronavirus-response-why-cuba-is-such-an-interesting-case-135749>

11 Cuba's response to COVID-19: lessons for the future

<https://www.emerald.com/insight/content/doi/10.1108/JTF-10-2020-0187/full/html>

12 The Impact of COVID-19 on Cuba in 2020

<https://www.clovekvtsni.cz/media/publications/1614/file/covid-19-on-cuba-2020-to-publish.pdf>

Цар тахлын онцлог менежмент хэрэгжүүлсэн орнууд

Цар тахлын эсрэг нилээд онцлог менежмент хэрэгжүүлж байгаа Швед улсыг ч анхаарч үзэх нь зүйтэй болов уу.

Швед: Швед улс хөл хорих арга хэмжээ огт аваагүй ч цар тахлын дэгдэлтийн хэмжээ нь хөл хорьсон орнуудынхтай ойролцоо, өөрөөр хэлбэл ижил үр дүнтэй байгаа нь сонирхол татаж буй юм. Иймээс цар тахлын эсрэг Швед улсын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ дэлхий нийтэд маргаан дагуулсаар байгаа билээ. Тус улсын улс төрчид өөрсдийн стратегийг “ойрын зайн гүйлт бус холын зайн марафон юм” гэж тайлбарлаж байна.

Шийдвэр гаргах түвшинд: Шведийн авч буй арга хэмжээг харахад төрийн бүх түвшний байгууллагууд, шашны болон сайн дурын байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг нягтруулсан байна. Төрийн эрх барих дээд байгууллага парламентаас засгийн газарт гамшгийн үеийн нөхцөлд байдалд ажиллах онцгой эрх олгосон ба энэ дагуу засгийн газраас тодорхой салбаруудад нэмэлт санхүүжилт, дэмжлэг үзүүлж байна. Эрүүл мэндийн болон нийтийн тээврийн салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ба учир нь иргэдийг нийтийн тээврээр үйлчлүүлэхээс татгалзахыг зөвлөсний улмаас орлого эрс багассан

ажээ. Түүнчлэн цар тахлын үед хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хүний нэр төрд халдахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус сайн дурын байгууллагууд, нэн эмзэг бүлэг болон ахмад настнуудын асрамжийн газрыг онцлон дэмжиж ажиллаж байна. Ахмад настны асрамжийн газруудаар зорчих болон 50-иас дээш оролцогчтой арга хэмжээг хориглосон ба шаардлагатай тохиолдолд 50-иас цөөн оролцогчтой арга хэмжээг хориглох эрхийг орон нутгийн удирдлагад өгчээ. Харин засгийн газрын зүгээс улс оронд хөл хорио тогтоох эрх зүйн чадвартай атлаа ийм алхам хийсэнгүй.¹³

Тус улсын гамшгийн тухай хуулиудаар улс орныг хамарсан онцгой нөхцөл байдлын үед төр, мужийн засаг захиргааны нэгж, байгууллагуудаас эхлээд иргэний нийгмийн байгууллагууд, өрх гэр, хувь хүн, улс төрийн нам эвсэл холбоод хүртэл ямар үүрэг хариуцлага хүлээж, эрх эдлэж ажиллах талаар тодорхой заасан байна.¹⁴ Энэ хүрээнд нийтийн эрх ашгийн төлөө иргэний хөдөлгөөн, улс төрийн намууд хуулиа мөрдөж ажиллаж байгаа бол нөгөө талаар эрх баригч нам үүсээд буй нөхцөл байдлын үед шийдвэр гаргахдаа парламентад суудалтай, суудалгүй гэлгүй улс төрийн намуудыг оролцуулсан үндэсний зөвшилцлийн хүрээнд тогтмол

13 European Committee on Democracy and Governance and COVID-19 Sweden
[https://www.coe.int/en/web/good-governance/cddg-and-covid#{%2264787140%22:\[23\]}](https://www.coe.int/en/web/good-governance/cddg-and-covid#{%2264787140%22:[23]})

14 Communicable Disease Act

https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/smittskyddslag-2004168_sfs-2004-168

хэлэлцүүлгийг зохион байгуулан ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарт: Шведийн цар тахлын нөхцөл байдлын ерөнхий менежментийг тус улсын эпидемиологич Андрес Тегнелл хариуцаж байгаа бөгөөд түүний хэлснээр “Швед улс бусдаас эрс өөр арга хэмжээ авч байгаа бус бусдын адил арга хэмжээг арай өөр хэлбэрээр хэрэгжүүлж байгаа” ажээ. Тэд олон нийтийг хамарсан арга хэмжээг хязгаарлах, бар рестораны үйл ажиллагааг оройн 8 цагт зогсоох, албан байгууллагуудыг зайнаас ажиллахыг дэмжих, их сургуулиудын сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх, хүн хоорондын зай баримтлах, гараа тогтмол угаахыг зөвлөж байгаа зэрэг нь бусад оронтой адил байгаа ч ихэнх арга хэмжээ нь хууль, журмаар бус зөвлөмжөөр зохицуулагдаж байгаагаараа арай өөр байна. А.Тегнелийн үзэж байгаагаар маск зүүх нь төдийлөн үр дүнтэй биш бөгөөд түүнээс илүү гараа тогтмол угааж, агааржуулалтыг сайтар хийх нь үр дүнтэй ба иргэд өөрсдөө хариуцлагатай байж, амьдралын хэв маяг, хандлагаа өөрчилж, цаг үеийн шаардлагыг сайн дураараа хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд улс орныг бүхэлд нь хаах бус тодорхой шаардлагатай хэсгийг хязгаарлах нь илүү үр дүнтэй ажээ. Түүнчлэн Шведийн Нийгмийн эрүүл мэндийн агентлаг урьдчилан сэргийлэх арга замуудыг илүү анхааран судлаж байна.¹⁵

Энэ стратегийг эсэргүүцэгчид эдийн засгийг хүний амьнаас дээгүүрт үзсэн хэмээн шүүмжилж байхад дэмжигчид үүнийг нийтийг хамарсан ажилгүйдэл үүсгэхгүй, ковид-19-тэй холбоогүй бусад өвчтний эмчилгээ, үйлчилгээнд хүндрэл учруулахгүй, эрх ашгийг хөндөхгүй, боловсролыг завсардуулахгүй ирээдүйд үүсэх томхон хэмжээний сөрөг үр дагавараас сэргийлсэн, урт хугацааны бодит стратеги гэж үзэж байна. Тегнелийн үзэж байгаагаар энэ бол эдийн засгийг эн тэргүүнд үзсэн стратеги биш юм. 2020 оны хоёрдугаар хагаст тус улсын ДНБ 11,9%-иар буурна гэж тооцож байснаас багаар буюу 8,6%-иар буурчээ. Тус улсын стратеги нь эдийн засгийн уналтыг харьцангуй багасгаж, жижиг бизнес эрхлэгчидэд үзүүлэх эдийн засгийн цохилтыг зөөлрүүлж, ЕХ-ны бусад оронд тулгараад байгаа ажилгүйдлээс зайлсхийх боломжийг олгосон бололтой.¹⁶

Харин цар тахлын хувьд бусад Нордикийн орнуудтай харьцуулвал халдвар болон нас баралт төдийлөн буурахгүй байгааг А.Тегнел тайлбарлахдаа Швед улс тэдгээр орнуудтай харьцуулвал томоохон хотуудын хүн амын төвлөрөл ихтэй, нийгэм-эдийн засгийн суурь чадамж султай эмзэг бүлгийн хүмүүсийн хувь өндөр мөн илүү аялах хандлагатай, хөл хөдөлгөөн ихтэй учраас Австри, Бельгитэй илүү төстэй юм гэжээ. Ковид-19-өөс шалтгаалсан үхлийн тоог тодорхойлох хамгийн найдвартай

15 Do Sweden’s COVID liberties cost lives?

<https://www.dw.com/en/do-swedens-covid-liberties-cost-lives/a-57268022>

16 The Swedish experiment: was it forward-thinking or not?

<https://www.worldfinance.com/strategy/the-swedish-experiment-forward-thinking-or-foolhardy>

аргуудын нэг болох хэтэрсэн үхлийн тоо нь хамгийн бага байгаа ЕХ-ны 10 улсын 5-д Швед улс орж байгааг А.Тегнел онцолжээ.

Мэдээллийн ил тод байдал:

Улс төрийн намуудыг оролцуулсан үндэсний зөвшилцлийн хүрээнд тогтмол хэлэлцүүлгийг зохион байгуулан ажиллаж байна. Энэ форматаар дамжуулан нийгэм, иргэддээ цар тахлын үеийн нөхцөл байдлын талаарх бүхий л мэдээлэл, бодит байдлыг цаг алдалгүй, ил тод мэдээлж байгаа нь төр засаг, иргэдийн хооронд үл ойлголцол үүсэхээс сэргийлж чадаж байна.

Иргэдийн хариуцлага:

Төр иргэдийн харилцан итгэлцэл дээр Шведийн цар тахлын менежмент хэрэгжиж байна.

Ерөнхийдөө Швед улс урьдчилан сэргийлэх, яг тодорхой чиглэсэн зорилтот, эмзэг бүлэгтээ онцгой анхаарал хандуулах, төрийн болон төрийн бус, олон нийт сайн дурын байгууллага, агентлагууд үйл ажиллагаагаа уялдуулан нягтруулах, иргэддээ итгэн тэдний ухамсар хандлага, хариуцлагад найдах, хязгаарлалт хоригийг аажмаар авч хэрэгжүүлснээрээ эдийн засгийн уналтыг зөөллөж ирээдүйд үүсэх эрсдэл, хүндрэлийг багасгахад чиглэсэн стратеги баримтлаж байна.

Австри: Ардчилсан засаглалтай, дэлхийн хамгийн чинээлэг орнуудын нэг энэ улсын эрүүл мэндийн систем сайн гэж үнэлэгддэг.

Шийдвэр гаргах түвшинд: ЕХ-ны олон гишүүн орны адилаар Австри ч мөн цар тахлын үеийг холбооны

засгийн газраас тусдаа таван цуврал хууль гарган зохицуулж байна. Уг хуулийн дагуу Нийгмийн асуудал, эрүүл мэнд, халамж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах яамны сайд, мужийн захирагч, дүүргийн удирдлагуудад олон нийтийн газрууд болон бизнесийн байгууллагуудад хязгаарлалт тогтоох эрх олгожээ. Түүнчлэн Дотоод хэргийн яамны удирдлага дор ажиллах үндэсний, бүсийн болон орон нутгийн хэмжээнд ажиллах үүрэгтэй Гамшгийн удирдлагын баг байдаг бөгөөд энэ багт холбогдох бүх яам, мужийн захирагчид, анхан шатны хариу арга хэмжээний байгууллагууд, иргэний хамгаалал, эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, чухал дэд бүтцийн газрын удирдлагууд багтан ажилладаг байна. Цар тахлын үед энэ баг үүргийнхээ дагуу мөн ажиллаж байгаа ба холбогдох гадаад, дотоодын байгууллага, удирдлагуудтай шаардлагатай мэдээллийг онлайнаар солилцон шуурхай ажиллаж байгаа ажээ.

Австри улс мөн л дэлхий нийтээр хэрэгжүүлж байгаа хөл хорионы дэглэмийг хэрэгжүүлж байгаа ба эмзэг бүлгийнхэн болон ахмад настнуудад хот, тосгоны олон нийт анхаарал хандуулан ажиллаж байна. Австри улсын оролцож буй Хил дамнасан хамтын ажиллагааны гурван хөтөлбөр нь хөтөлбөрт оролцогчдын датаг цуглуулан цар тахлын хямралын талаарх дүгнэлтийг хийхээр ажиллаж байгаа аж. Улс орны хэмжээнд бодлогын томоохон өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй, дижитал шийдэл, цахимаар ажиллахыг дэмжиж байна. Холбооны муж улсууд

цар тахлын үед засгийн газрын нэг удирдлага дор нэгдэж ажилласан ба холбооны улсын яамд болон есөн мужид ажлын уялдаа холбоог сайжруулж, шуурхай ажиллах зорилгоор хямралын менежментийн тусгай бүлгүүдийг зохион байгуулсан нь олон нийтэд мэдээллийг шуурхай түгээхэд тустай байгаа аж.¹⁷ Холбооны улс гэхэд засаглал нь уян хатан байж, нэгдмэл удирдлагыг хэрэгжүүлсэн нь давуу тал болжээ.¹⁸

Эрүүл мэндийн салбарт: Цар тахал дэгдэхээс өмнө олон улсын шинжээчид тус улсыг эмнэлэгийн орны тоогоо цөөрүүлэхийг зөвлөж байсан ч засгийн газар татгалзсан нь оножээ. Тус улсын засгийн газар эрүүл мэндийн салбарт

шинээр хөрөнгө хуваарилахаас илүү байгаа нөөцөө оновчтой хуваарилах бодлого барьжээ. Сайн тоноглогдсон эмнэлэгүүдээ ковид-19-ийн эмчилгээний төв болгох, эрүүл мэндийн ажилтнуудыг энэ чиглэлд дахин мэргэшүүлэх зэрэг зохион байгуулалтыг хийсэн байна.

Мэдээллийн ил тод байдал: Цар тахлын нөхцөл байдлын болон хариу арга хэмжээний талаарх мэдээлэл нээлттэй, ил тод, ойлгомжтой байна.

Иргэдийн хариуцлага: Тус улс нь иргэдийн засгийн газартаа итгэх итгэл өндөр байдаг улсуудын нэг тул аливаа бодлого амжилттай хэрэгжих суурь болдог байж болох юм.

Дүгнэлт

Цар тахлын энэ үед засаглалын ямар хэлбэр байхаас үл хамааран сайн засаглал, шийдэл чухал болох нь харагдаж байна. Судалгаанаас харахад засаглалын стандарт болон манлайлал сайтай, эв нэгдэлтэй, нэгдмэл ойлголттой, нээлттэй ил тод мэдээлэлтэй, хувь хүний эрх нь үүрэг хариуцлагаар хязгаарлагддаг гэдгийг иргэд нь ухамсарласан улс орнууд бусдаас илүү цар тахлыг амжилттай зохион байгуулж, даван туулж байгаа дүр зураг ажиглагдаж байна.¹⁷¹⁸

Улс төрийн ямар дэглэмтэй байхаас үл хамааран аливаа давагдашгүй хүчин зүйлийг харьцангуй амжилттай тэсч гарахад улс орнуудын хувьд

дараах хэдэн хүчин зүйлс чухал болох нь ажиглагдана. Үүнд 1. Нэгдмэл ойлголттой байж, нягт хамтран ажиллах. Эрх баригч нам, сөрөг хүчин, засгийн газар, ард иргэд, эрдэмтэн судлаачид, олон нийтийн байгууллагууд бүгд хамтран ажиллаж, ойлголтоо нэгтгэн нэгдсэн төлөвлөгөөний дагуу харилцан бие биеэ дэмжин нягт хамтран ажиллах. 2. Засгийн газраас гаргаж буй аливаа шийдвэр мэргэжлийн эрдэмтэдийн судалгаанд үндэслэсэн, шинжлэх ухаанч, ойлгомжтой байх, иргэд үүргээ ухамсарладаг, хариуцлагатай байх. 3. Мэдээллийг ямарваа цензур хяналтгүй, ил тод нээлттэй, иргэд олон нийтийг

17 European Committee on Democracy and Governance and COVID-19 Austria

[https://www.coe.int/en/web/good-governance/cddg-and-covid#{%2264787140%22:\[0\]}](https://www.coe.int/en/web/good-governance/cddg-and-covid#{%2264787140%22:[0]})

18 Europe's Covid-19 outliers: German, Austrian and Swiss policy response during the early stage of the 2020 pandemic

<https://www.sciencedirect.com/science/article/pii/S2211883720300964>

төөрөгдүүлэхээргүй, ойлгомжтой, тодорхой өгч байх. 4. Эрүүл мэндийн систем сайн хөгжсөн, иргэдэд хүртээмжтэй, ухаалаг зохицуулалттай байх, цар тахал өнгөрсөн ч энэ салбарт үр өгөөжийг тооцсон ухаалаг хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийх нь дараагийн тааварлашгүй нөхцөл байдлын бэлтгэл болох юм.

Үүний зэрэгцээ цар тахлыг амжилттай зохион байгуулахад улс үндэстнүүдийн уламжлал, зан заншил, соёл, сэтгэлгээний онцлог,

ялгаатай байдал, амьдралын хэв маяг, хэт төвлөрөл зэрэг нь нөлөөлж байх магадлалтай ба улс орнуудын нийгмийн (хамтлаг, хүмүүсийн) өөрийгөө зохион байгуулах чадамж, удирдлагын засаглал (арга барил)-ын тухайн нөхцөл байдалд тохируулан хурдан маневарлах, харилцан үр дүнтэй хамтран ажиллах чадавх хэрхэн нөлөөлж буйг шинжээч Л.Мьютланы боловсруулсан удирдлагын арга барилын гурван загвараар шинжилж үзэж болох юм.

Ашигласан материал

1. Tanya Lewis, 2021 “How the U.S. Pandemic Response Went Wrong- and What Went Right-during a Year of COVID” <https://www.scientificamerican.com/article/how-the-u-s-pandemic-response-went-wrong-and-what-went-right-during-a-year-of-covid/>
2. BROOKINGS DOHA CENTER, 2021 “Policy & Institutional Response to COVID-19: New Zealand” pp. 9. <https://www.brookings.edu/wp-content/uploads/2021/01/MENA-COVID-19-Survey-New-Zealand-.pdf>
3. Wei Liu, Wei-Jie Guan, Nan-Shan Zhong, 2020, “Strategies and Advances in Combating COVID-19 in China” <https://www.sciencedirect.com/science/article/pii/S209580992030285X>
4. Prof Zhongjie Li, PhD, Qiulan Chen, PhD, Prof Luzhao Feng, PhD, Lance Rodewald, MD, Yinyin Xia, PhD, Hailiang Yu, MMed et al, 2020 “Active case finding with case management: the key to tackling the COVID-19 pandemic” pp. 64-65. [https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(20\)31278-2/fulltext](https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(20)31278-2/fulltext)
5. Talha Burki, 2020 “China’s successful control of COVID-19” pp. 1240. [https://www.thelancet.com/journals/laninf/article/PIIS1473-3099\(20\)30800-8/fulltext](https://www.thelancet.com/journals/laninf/article/PIIS1473-3099(20)30800-8/fulltext)
6. Julia Palik, 2020 “Iran and COVID-19: Timing Matters” pp. 2. <https://mideast.prio.org/utility/DownloadFile.ashx?id=38&type=publicationfile>

7. Maryam Rassouli, Hadis Ashrafizadeh, Azam Shirinabadi Farahani, Mohammad Esmaeil Akbari, 2020 “COVID-19 Management in Iran as One of the Most Affected Countries in the World: Advantages and Weaknesses” pp. 2. <https://www.frontiersin.org/articles/10.3389/fpubh.2020.00510/full>
8. Leonid Petrov, 2021 “COVID-19 in North Korea” <https://www.policyforum.net/covid-19-in-north-korea/>
9. Kim Won Jin, 2021 “No cases? No chance. The truth about North Korea and Covid-19” <https://www.wired.co.uk/article/north-korea-covid-news>
10. Emily Moris, Ilan Kelman, 2020 “Coronavirus response: why Cuba is such an interesting case” <https://theconversation.com/coronavirus-response-why-cuba-is-such-an-interesting-case-135749>
11. Lana L. Wylie, 2020 “Cuba’s response to COVID-19: lessons for the future” pp. 2-3. <https://www.emerald.com/insight/content/doi/10.1108/JTF-10-2020-0187/full/html>
12. Iyanu Osunmo, 2020 “The Impact of COVID-19 on Cuba in 2020” pp. 5-6. <https://www.clovekvtisni.cz/media/publications/1614/file/covid-19-on-cuba-2020-to-publish.pdf>
13. Council of Europe, 2020 “European Committee on Democracy and Governance and COVID-19 Sweden” [https://www.coe.int/en/web/good-governance/cddg-and-covid#%2264787140%22:\[23\]](https://www.coe.int/en/web/good-governance/cddg-and-covid#%2264787140%22:[23])
14. Sweden Ministry of Social Affairs, 2004 “Communicable Disease Act” https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/smittskyddslag-2004168_sfs-2004-168
15. Teri Schultz, 2021 “Do Sweden’s COVID liberties cost lives?” <https://www.dw.com/en/do-swedens-covid-liberties-cost-lives/a-57268022>
16. Emily Cashen, 2021 “The Swedish experiment: was it forward-thinking or not?” <https://www.worldfinance.com/strategy/the-swedish-experiment-forward-thinking-or-foolhardy>
17. Council of Europe, 2020 “European Committee on Democracy and Governance and COVID-19 Austria” [https://www.coe.int/en/web/good-governance/cddg-and-covid#%2264787140%22:\[0\]](https://www.coe.int/en/web/good-governance/cddg-and-covid#%2264787140%22:[0])
18. Zachary Desson, Lisa Lambert, Jan Willem Peters, Michelle Falkenbach, Lukas Kauer, 2020 “Europe’s Covid-19 outliers: German, Austrian and Swiss policy response during the early stage of the 2020 pandemic” <https://www.sciencedirect.com/science/article/pii/S2211883720300964>

Country-specific approaches to combating the pandemic; governance capacity

Gerelt-Od Namsraidorj

Research Fellow, Institute for National Security Studies

Ulaanbaatar, Mongolia

gerelt-od@niss.gov.mn

Abstract: *During the most severe pandemic period in the last hundred years every country is handling it with their own approach. The pandemic reveals the differences among them in terms of leadership and strengths and weaknesses of the countries' governance. What type of management has proved effective in this time of pandemic and what has not? This research examines whether it is related to the political regimes by country (form of governance); the pandemic management is compared across the countries with democratic, authoritarian and totalitarian regimes, as well as unique approaches taken by the countries.*

Keywords: *Pandemic, political regimes, governance, management*

<i>The day of submission:</i>	2021.06.23
<i>Completion of review:</i>	2021.06.27
<i>Final decision for acceptance:</i>	2021.06.30